

Орос хэлний нөхцөлт үйл (деепричастие)¹, түүний утгыг монгол хэлэнд буулгах тухай асуудалд

(М.Шолоховын “Хүний хувь заяа өгүүллэгийн орчуулгын жишээн дээр”)

Сосорбарамын Эрдэнэмаам^{ORCID}

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Орос хэлний тэнхимийн
зөвлөх профессор, Улаанбаатар, Монгол Улс

Хүлээн авсан - Received:
2024-10-24

Засварласан - Revised:
2024-11-17

Хэвлэгдсэн - Published:
2024-12-25

erdenemaam@msue.edu.mn

ORCID: [0009-0000-9841-5551](https://orcid.org/0009-0000-9841-5551)



© 2024, Author(s)

Хураангуй: Орос хэл үзэж буй монгол оюутан суралцагчдад нэлээд бэрхшээл учруулдаг олон сэдэв байдгийн нэг нь нөхцөлт үйл, түүний орчуулга юм. Иймд орос хэлний нөхцөлт үйл үгийн үүрэг, хэрэглээний онцлог хийгээд түүнийг монгол хэлэнд хэрхэн орчуулах талаар энэхүү өгүүлэлд товч багцлан харуулахыг зорив. Хэрхэн орчуулах тухай жишээ баримтыг нэрт эрдэмтэн, орчуулагч, Төрийн соёрхолт Бямбын Ринчиний орчуулсан орос-зөвлөлтийн нэрт зохиолч, Нобелийн шагналт М.Шолоховын “Хүний хувь заяа” өгүүллэгээс авсан болно. Орос хэлний нөхцөлт үйл үгийн тухайд магистрантур, докторантурын түвшний сургалтаас хальсан дэлгэрэнгүй мэдээлэл өгч, эрдэмтэн судлаачдын зөрүүтэй байр суурийн талаар өгүүлэн, энэ сэдвийг судлах явцад монгол суралцагчдад ямар бэрхшээл тулгардаг талаар мэдээлж, монгол хэлэнд орчуулсан сонгодог жишээ баримттай танилцуулсан нь энэхүү өгүүллийн гол үр дүн хэмээн үзэж байна.

Түлхүүр үг: төгс ба төгс бус байдал, нийцэл болон дүйцлийн зарчим, үндэсний онцлог

ОРШИЛ

Түүхэн судалгаанаас үзвэл, орос хэлний нөхцөлт үйл үг эртний орос хэлний үйлт нэрийн өөрөө үйлдэх хэвийн нэрлэхийн тийн ялгалын богино хэлбэрээс үүссэн гэх бөгөөд “деепричастие” гэдэг нэр томъёог хэл судлаач, зохиолч, шашны зүтгэлтэн Мелетий Смотрицкий 1619 онд хэвлүүлсэн “Грамматика” хэмээх алдарт бүтээлдээ анх оруулж иржээ. Түүний энэ алдарт бүтээл хоёр зууны турш олон дахин хэвлэгдэж, тухайн үедээ хэл шинжлэлийн судалгаа, сургалтад ихээхэн үүрэг гүйцэтгэсэн аж. Үүний нэгэн тод жишээ бол суут эрдэмтэн Михаил Ломоносов энэхүү бүтээлийг “миний эрдэмд шамдах үүд хаалга болсон юм” хэмээн өндрөөр үнэлж байжээ (Ломоносов. Страница

¹ С.Галсан профессорын монголын орос хэл судлалд оруулсан нэр томъёогоор авав: С.Галсан. Сопоставительная грамматика русского и монгольского языков. УБ., 1975. стр. 264. Мөн А.Шархүү “Деепричастие и деепричастные конструкции в современном монгольском языке /в сопоставлении с аналогичными фактами русского языка/” (“Монгол хэлний нөхцөлт үг, түүний хэлхэцийг орос хэлний холбогдох зүйлтэй зэрэгцүүлэн судлах нь”) сэдвээр 1971 онд ОХУ-ын Москва хотноо хэлбичгийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалсан байдаг.

автора: стихи, статьи). Залуу идэр судлаач дүү нартаа сонирхуулахад, ном эрдэм сурахаар гэрээсээ оргож, загасчдын завинд дайгдан явсаар мөрөөдлийнхөө Москваг бараадсан 19 настай бяцхан хүү Миша Ломоносов халаасандаа гуравхан рубльтэй, аранзандаа Смотрицкийн “Хэл зүй”, Магницкийн «Арифметик» гэсэн ердөө хоёрхон номтой явсан гэдэг.

Нөхцөлт үйл үг бие даасан үгсийн аймаг мөн эсэх талаар үе үеийн эрдэмтэд санал зөрөлдсөөр ирсэн бөгөөд өнөө хэр нэгдсэн байр суурьд хүрээгүй хэвээр байгаа юм. 1980 онд ЗХУ-ын ШУА-иас эрхлэн хэвлүүлж, өнөөг хүртэл баримталсаар ирсэн, судлаачдын дунд “Академийн хэл зүй” гэж алдаршсан “Грамматика русского языка” хэмээх суурь бүтээлд түүнийг үгсийн аймгийн тоонд оруулаагүй бөгөөд ““Нөхцөлт үйл нь үйл үгийн онцгой хэлбэр агаад үйл үг, дайвар үг² (наречие)-ийн аль алиных нь утгыг илэрхийлнэ. ...Үйл үгийн нэгэн хэлбэр боловч цаг заадаггүй, өгүүлбэрт гол үйлийн тодотголын үүрэг гүйцэтгэнэ” хэмээн тодорхойлжээ (Русская грамматика, 1980, хууд. 669). Бидний дайвар үг хэмээн нэрлэсээр байгаа *наречие* нь “үйлийн янз бүрийн нхцөл байдлыг илтгэнэ” хэмээн тодорхойлсон байдаг (Ломоносов, 1755, хууд. 24).

Ийнхүү түүнийг бие даасан үгсийн аймаг мөн эсэх талаар судлаачид олон зууны турш нэгдмэл нэг санаанд хүрч чадахгүй байгаагаар үл барам үг зүйн шинж тэмдгийнх нь хувьд ч өөр өөр байр суурьтай байсаар ажээ. Энд мөн л хоёр өөр санал давамгайлдаг байна. В.В.Виноградов, П.С.Кузнецов, Н.М.Шанский, А.Н.Тихонов нарын зэрэг эрдэмтэд нөхцөлт үйл үг цагийн айтай, түүний байдлын ай нь үүссэн үйл үгийнх нь байдлын айнаас хамаарна хэмээн үздэг бол Ф.И. Буслаев, В.И. Чернышев, Д.Н. Кудрявский, Т.П. Ломтев ((Буслаев. Ф. И. 1867, хууд.24; Чернышев. В.И., 1914, хууд.119; Кудрявский. Д.Н.,1916, хууд. 134; Ломтев. Т. П., 1961, хууд. 89.) нарын зэрэг судлаач эдгээр бүлэг үгийг цагийн айтай, ингэхдээ төгс бус байдлын үйл үгээс үүссэн нь одоо цагийн, төгс байдлын айгаас үүссэн нь өнгөрсөн цагийнх хэмээн үздэг ажээ.

Үр дүн

Эрдэмтэн судлаачдын сонирхлыг ихээр татдаг, маргааны бай болсон тухайн ухагдахууны талаар энэхүү өгүүлэлд бичихдээ өнөөг хүртэл хүчин төгөлдөр мөрдөж буй, өөрөөр хэлбэл, орчин цагийн утга зохиолын орос хэлний хэм хэмжээг тогтоогч лужин гэгддэг “Русская грамматика-80”-ыг чиг баримжаа болгон авч үзлээ. Өөрөөр хэлбэл, бүх шатны сургуульд зааж сургаж байгаа орос хэлний хэл зүй ёсоор бол, орос хэлний нөхцөлт үйл үг нь үүсгэсэн үйл үгээсээ хамааран төгс ба төгс бус байдлын гэж хоёр хуваагдах бөгөөд тухайн өгүүлбэрийнхээ өгүүлэхүүнийг цаг хугацаа, орон байр, учир шалтгааны үүднээс тодотгоно. Жишээлбэл: *опаздывая* нь *опаздывать* хэмээх төгс бус байдлын үйл үгээс үүссэн тул мөн төгс бус байдлын нөхцөлт үйл үг юм. “Студент спешит в университет, *опаздывая* на лекцию” гэсэн өгүүлбэрт *опаздывая* хэмээх төгс бус байдлын нөхцөлт үйл үг гол өгүүлбэрийн *спешит* буюу “яарч байна” гэх өгүүлэхүүний учир шалтгааныг тодотгож байна. *Почему студент спешит в университет? – Потому что опаздывает на лекцию (Оюутан яагаад сургуульдаа яарч байна вэ? – Лекцнээсээ хоцорч байгаа учраас яарч байна)*. Харин *опоздав* нь *опоздать* гэх төгс байдлын үйл үгээс үүссэн тул мөн төгс байдлын нөхцөлт үйл үг юм. *Опоздав на лекцию, студент извинился перед профессором*. Энэ өгүүлбэрт *опоздав* хэмээх төгс байдлын нөхцөлт үйл үг гол өгүүлбэрийн өгүүлэхүүний мөн л учир шалтгааныг тодотгож байна. *Оюутан профессороос яагаад уучлалт гуйсан бэ? – Лекцнээс хоцорсон учраас уучлалт гуйв*.

² Ш.Барайшир. Монгол хэлний дайвар үг нэг сэдэвт бүтээлдээ энэхүү нэр томъёог анх санал болгосон бөгөөд монголын орос хэл судлалд одоо хэр хэрэглэгдсэн авай.

Үг зүйн үүднээс авч үзвэл, нөхцөлт үйл үгэнд цаг заасан ямар нэгэн хэлбэр байхгүй, гэхдээ илэрхийлж байгаа үйлийнх нь цаг гол үйл үгийн цагт хамаарна. Энэ үүднээс авч үзвэл дээрх “Студент спешит в университет, *опаздывая* на лекцию” гэсэн өгүүлбэрийн өгүүлэхүүн нь буюу “спешит” гэдэг үйл үг одоо цагт хэлбэржсэн байгаа учраас “опаздывая” гэсэн нөхцөлт үйл үг мөн л одоо цагийг илэрхийлж байна. Харин “Опоздав на лекцию, студент извинился перед профессором” гэх өгүүлбэрт гол өгүүлбэрийн өгүүлэхүүн буюу “извинился” гэдэг үйл үг өнгөрсөн цагт хэлбэржсэн байгаа тул “опоздав” гэдэг нөхцөлт үйл үг мөн л өнгөрсөн цагийг илэрхийлж байгаа болно. Өөрөөр хэлбэл, нөхцөлт үйл үг гол өгүүлбэрийнхээ өгүүлэхүүний цагаас хамаарч одоо, өнгөрсөн, ирээдүй цагийг гурвууланг нь илэрхийлнэ гэсэн үг юм. Жишээлбэл, дараах гурван өгүүлбэрийг анхааралтай ажиглана уу: а/ Студент спешит в университет, *опаздывая* на лекцию (Лекцнээсээ хоцорч байгаа учраас оюутан сургуульдаа яарч байна). б/ Студент спешил в университет, *опаздывая* на лекцию (Лекцнээсээ хоцорч байсан учраас оюутан сургуульдаа яарч байлаа). в/ Студент будет спешить в университет, *опаздывая* на лекцию (Лекцнээсээ хоцрох гээд байгаа учраас оюутан сургуульдаа яарах болно).

Үүний зэрэгцээ өөр нэг онцлогийг цохон тэмдэглэх нь зүйтэй, учир нь орос хэл үзэж буй монгол оюутан сурагчид чухам энэхүү онцлогийг эс ойлгосноос алдаа их гаргадаг талтай. Учир юун хэмээвээс, нөхцөлт үйл үгээр илэрч буй үйл, гол өгүүлбэрийн өгүүлэхүүнээр илэрч буй үйл дундаа нэг эзэнтэй байна. Дахиад дээрх жишээгээ авъя: *Студент спешит в университет, опаздывая на лекцию* – энэ өгүүлбэрт хоцорч байгаа нь ч, яарч байгаа нь ч оюутан. Үүнийг эс ойлгосноос манай зарим оюутан суралцагч хоёр өөр эзэн биетэй мэт ойлгогдохоор бичиж алдаа гаргах нь нэлээд элбэг. Жишээлбэл: *Подъезжая к дому, у меня слетела шляпа* – зүй нь энэ өгүүлбэрт *подъезжая* гэдэг нөхцөлт үйл үг, *слетела* гэдэг өгүүлэхүүн хоёрын эзэн бие нэг байх учиртай. Энэ үүднээс авч үзвэл, *Юу хийссэн бэ? – малгай хийссэн; Байшинд хэн дөхөж очсон бэ? – малгай дөхөж очсон.* Өөрөөр хэлбэл, дээрх дүрмийг зөрчсөнөөр утгын алдаа (малгай өөрөө явсаар дөхөж очсон) гаргах бөгөөд, энэхүү жишээний хувьд инээдэмт байдал үүсэхэд хүргэсэн байна.

Багагүй алдаа дагуулдаг өөр нэг онцлог гэвэл, төгс бус байдлын нөхцөлт үйл үгээр илэрч буй үйл, өгүүлэхүүнээр илэрч буй үйл цаг хугацааны хувьд зэрэг үйлдэгддэг бол төгс байдлын нөхцөлт үйл үгээр илэрч буй үйл нь өгүүлэхүүнээр илэрч буй үйлээс өмнө болж өнгөрнө. Дахиад дээрх хоёр жишээгээ харьцуулан харцгаая: *Студент спешит в университет, опаздывая на лекцию* – энэ өгүүлбэрт *опаздывая* нь төгс бус байдлын нөхцөлт үйл үг учраас хожигдох, яарах гэсэн хоёр үйл цаг хугацааны хувьд давхцаж байна гэсэн үг. Давхцах давхцахдаа өгүүлэхүүн аль ч цагт хэлбэржсэн байсан адилхан давхцана. Харин *Опоздав на лекцию, студент извинился перед профессором* – энэ өгүүлбэрт *опоздав* нь төгс байдлын нөхцөлт үйл үг учраас түүгээр илэрхийлж буй *хоцрох* үйл *извинился* гэх өгүүлэхүүнээр илэрч буй *уучлалт гуйх* үйлээс заавал өмнө болж өнгөрөх учиртай. Үүнийг илүү тод харуулахын тулд өөр нэг жишээ авъя: *Читая книгу, брат лежал на диване* – энэ өгүүлбэрт *читая* төгс бус байдлын нөхцөлт үйл үг учраас *униших, хэвтэх* гэсэн хоёр үйл цаг хугацааны хувьд давхцаж байна гэсэн үг, өөрөөр хэлбэл, тухайн оюутан ном уншингаа хэвтэж байна гэсэн үг юм. Харин *Прочитав книгу, студент пошёл гулять* – энэ өгүүлбэрт буй *прочитав* нь төгс байдлын нөхцөлт үйл үг учраас *униших* үйл нь өгүүлэхүүнээр илэрч буй *зугаалахаар одох* үйлээс түрүүлж болсон гэсэн үг юм.

Орос хэл судлалын салбарын нэрт эрдэмтэн агсан А.Шархүү монгол хэлний нөхцөлт үг, түүний хэлхэцийг орос хэлний нөхцөлт үйлтэй зэрэгцүүлэн судласан ганц сэдэвт бүтээлдээ орчин цагийн

утга зохиолын монгол хэлний найруулгын өөр өөр төрөлд хамаарах ном, зохиол, ам ярианы материалд тулгаарлан судлаж, үгийн сан, үг зүй, өгүүлбэрт гүйцэтгэх үүргийг нарийвчлан тогтоох, улмаар хэл ба хэлэхүйд гүйцэтгэх үүргийнх нь талаас хэв шинжээрээ монгол хэлнээс ялгаатай орос хэлний адил төсөөтэй иш баримтууд лугаа зэргэцүүлэн жишиж, тодорхой зөвлөмж, санал боловсруулсан байдаг нь орос монгол зэрэгцүүлсэн хэл шинжлэлийн асуудлаар ном сурах бичиг, гарын авлага, хичээлийн хэрэглэгдэхүүн боловсруулахад чухал хэрэглэгдэхүүн болсоор байгаа энэ дашрамд онцлон тэмдэглүүштэй.

Одоо орос хэлний нөхцөлт үйл үгийн утгыг монгол хэлэнд хэрхэн буулгасныг өгүүллийн эхэнд дурдсан зохиолын жишээнд тулгуурлан товч авч үзье. Их эрдэмтэн гүүшийн орчуулга бидэнд үлгэр жишээ, жишиг болохын учир энэхүү зохиолыг сонгон авснаа дурьдах нь илүүц буй заа. Үлгэр жишээ орчуулгын тод жишээ болсных нь тухайд С.Галсан профессор “Орчуулга сөхөхөд” хэмээх судалгааны өгүүлэлдээ (Галсан.С, 1976) дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг. Ринчин абугай үнэхээр үг үсэгт баригддаггүй, агуулгыг бүрэн дүүрэн гаргахыг эрхэмлэдэг нэгэн байсныг тэр өгүүлэлд тодорхой жишээ баримтаар харуулсан байдаг билээ.

Энэхүү өгүүлэлд нөхцөлт үйл бүхий өгүүлбэр нийт 32 байгаагийн 65,6%-ийг төгс бус байдлын, 34,4%-ийг төгс байдлынх эзэлж байгаагаас үзэхэд, орчин цагийн орос хэлэнд төгс бус байдлын нөхцөлт үйл үгийг түлхүү хэрэглэж байна гэж дүгнэж болохоор байгаагийн зэрэгцээ бүх тохиолдлын дөнгөж 15% нь өгүүллэгийн гол баатрын ярианд тааралдаж байгаа нь нөхцөлт үйл үг энгийн ярианд бараг хэрэглэгддэггүйг нотлон харуулж байна.

Мөн орос хэлний нөхцөлт үйл үг нь гол өгүүлбэрийн өгүүлэхүүнээр илэрч буй үйлийн орон цаг, учир шалтгаан, байрыг тодотгон харуулж буй үйл үгийн онцгой хэлбэр учраас тэдгээрийг монгол хэлэнд орчуулахад өгүүлбэр, холбоо үгийн бүтцэд орсон ямар нэг үйл үгийг дараагийн үйл үгтэй холбох харьцааг заах үүрэг бүхий (Өнөрбаян.Ц, 2004) нөхцөлдүүлэн холбох аль нэгэн нөхцлийн тусламжтайгаар орчуулсан байна. Тухайлбал: “Пара сытых лошадей, в струну натягивая постромки, еле тащила тяжелую бричку” гэсэн төгс бус байдлын нөхцөлт үйлийн хэлхэцтэй өгүүлбэрийг “...тарган хоёр морь дөрвөн дугуйтай хүнд тэргийг *татлагаа сунатал зүтгэж*, чүү чамай гарч явахад...” хэмээн зэрэгцүүлэн холбох “-ж” нөхцлийг ашиглан орчуулжээ. Энэ бол төгс бус байдлын нөхцөлт үйл үгээр илэрч буй үйл нь гол өгүүлбэрийнхээ өгүүлэхүүнээр илэрч буй үйлтэй нэгэн цагт зэрэгцэн болж өнгөрдөг хэмээх дүрмийн тод нотолгоо болой. Дашрамд дурьдахад, дээр өгүүлсэнчлэн, хэд хэдэн жижиг өгүүлбэрийг нэг том нийлмэл өгүүлбэр болгож, ойлгохуйяа хялбар болгон орчуулсан газар цөөнгүй тул энэхүү жишээнд гарч байгаагчлан бүтэн өгүүлбэрийг талласан мэт харагдаж байгаа билээ.

Тэгвэл төгс байдлын нөхцөлт үйл бүхий өгүүлбэрийг хэрхэн орчуулсан тухай жишээ авья: “В конце марта из Приазовья подули теплые ветры, и уже через двое суток начисто оголились пески левобережья Дона, в степи вспухли набитые снегом лога и балки, *взломал лед*, бешено взыграли степные речки, и дороги стали почти совсем непроездны” гэсэн өгүүлбэрийг “Туравдугаар сарын сүүлчээр Азов тэнгисийн хавиас дулаан салхи салхилж, хоёр хоноход Доны зүүн биеийн элсний цас ханзран арилж, хөдөө тийшээ цас дүүрсэн гуу жалга сагсайгаад, хөдөөгийн горхи *мөсөө зад татан* уухилж, газар сайгүй зам муухай болоод явахын арга тасрах шахсан тэр үед надад Букановын суурин орох хэрэг гарч билээ” гэж хам холбох “-н” нөхцлийг ашиглан орчуулжээ. Орос хэлний төгс байдлын нөхцөлт үйл үгээр илэрч буй үйл нь гол өгүүлбэрийнхээ өгүүлэхүүнээр илэрч уй үйлээс өмнө болж

өнгөрснийг илтгэдэг учир энэ өгүүлбэрт “эхлээд мөсөө зад татсан, дараа нь зам харгуйг муухай болгосон” хэмээх утга гарч байна.

Тухайн өгүүллэг дэх нөхцөлт үйл үгийн орчуулгыг нийтэд нь авч үзвэл, төгс бус байдлын нөхцөлт үйл үгийг орчуулахад 43,7%-д нь зэрэгцүүлэн холбох “-ж”, 31,2%-д нь урьдчилан холбох “-аад”, 18%-д нь болзон холбох “-вал” нөхцлийг ашиглажээ. Энэ нь дээр өгүүлсэнчлэн, төгс бус байдлын нөхцөлт үйлийн хэлхэц бүхий нийлмэл өгүүлбэрт гарч байгаа хоёр үйл цаг хугацааны хувьд нэгэн зэрэг болж өнгөрдөг гэсэн дүрмийг нотолж байна. Гэхдээ хоёр үйл цаг хугацааны хувьд зэрэг болж өнгөрдөг юм бол орчуулгад яагаад урьдчилан холбох нөхцөл ашигласан бэ? гэсэн асуулт гарах нь зүй ёсны хэрэг билээ. Тухайлбал, “Один из них, *не доходя шагов нескольких*, плечом дернул, автомат снял” гэсэн өгүүлбэрийг “Дайсны нэг цэрэг *дэргэд минь шахуу хүрч ирээд*, мөрнөөсөө автоматаа мулталлаа” гэж, урьдчилан холбох “-аад” нөхцлийг ашиглан орчуулжээ. Урьдчилан холбох нөхцөл ашигласнаар “эхлээд дэргэд нь ирсэн, дараа нь автоматаа мулталсан” гэж ойлгогдохоор байгаа боловч, орос өгүүлбэртээ бол “дэргэд нь дөхөж ирэх, автоматаа мултлах” гэсэн хоёр үйл утгаа цаг хугацааны хувьд нэгэн зэрэг болсон гэсэн санаа байгаа юм. Үүнийг орчуулагч ойлгоогүй, анзаараагүй гэх ямар ч үндэс байхгүй бөгөөд, гагцхүү монгол уншигч уншихад өгүүлбэрийг илүү сонсголонтой болгох гэж зориуд ингэж хэрэглэжээ хэмээн үзэх ёстой болов уу. Харин хэд хэдэн өгүүлбэрт төгс бус байдлын нөхцөлт үйлийн хэлхэцийг орчуулаагүй тохиолдол байна. Тухайлбал, “Хорошо было сидеть на плетне вот так, одному, *целиком покорясь тишине и одиночеству*, и, сняв с головы старую солдатскую ушанку, сушить на ветерке мокрые после тяжелой гребли волосы, бездумно следить за проплывающими в блеклой синеве белыми грудастыми облаками” гэсэн өгүүлбэрт буй *целиком покорясь тишине и одиночеству* гэх хэлхэцийг орхин “Гав ганцаар, тэр чимээгүй нам гүм газар сүлжмэл хашаан дээр суугаад чихэвчтэй цэрэг хуучин малгайгаа аваад сунатлаа сэлсээр хөлөрсөн үсээ хатаан, цайвар хөх огторгуйд хөвж байгаа сэмжин цагаан сэвсгэр үүл харж, юм хүм бодолгүй санаа амар суухад тун ч сайхан санагдлаа” хэмээн орчуулжээ. Энэ тохиолдолд тухайн хэлхэцээр илэрхийлсэн санаа өгүүлбэртээ ерөнхийд нь шингэсэн хэмээн үзэж болохоор тул орчуулагчийн алдаа эндэгдэл гэх ямар ч үндэс мөн л байхгүй байна хэмээн дүгнэх нь зүйтэй болов уу.

Өгүүллэгт буй төгс байдлын нөхцөлт үйлийн хэлхэц бүхий нийт өгүүлбэрийн 72,7%-ийг урьдчилан холбох “-аад”, 27,3%-ийг угтуулан холбох “-тал” нөхцлөөр орчуулсан нь төгс байдлын нөхцөлт үйлээр илэрч буй үйл гол өгүүлбэрийнхээ өгүүлэхүүнээр илэрч байгаа үйлээс цаг хугацааны хувьд өмнө нь болж байгааг илтгэнэ гэсэн дүрмийг зуун хувь нотлон харуулж байна. Тухайлбал: “Я присел на него, хотел закурить, но, *сунув руку в правый карман* ватной стеганки” гэсэн өгүүлбэрийг “Эргийн элсэн дээр ойрхон хэвтэж байсан бургасан сүлжмэл хашаан дээр очиж суугаад, тамхи татах гэж хөвөнтэй богино дээлнийхээ баруун халаасанд *гараа хийтэл*, ...” хэмээн “*сунув*” гэх төгс байдлын нөхцөлт үйл үгийг “*хийтэл*” гэж угтуулан холбох нөхцөл ашиглан орчуулжээ.

Эцэст өгүүлэхэд, орос хэлний нөхцөлт үйлийн хэлхэц нь тухайн хэлийг үзэж буй оюутан суралцагч, ер нь сонирхон оролдож буй хэнд ч болов нэлээн хүнд сэдвийн нэг боловч, сайн орчуулагчийн хийсэн орчуулгын бүтээлийг шимтэн уншиж, тухайн хэлхэц бүхий өгүүлбэрийг хэрхэн яаж буулгасныг сайтар ажиглан, дүн шинжилгээ хийж, бичиж тэмдэглэж авч байваас өөрийн болгон эзэмшихэд нэн дөхөмтэй ажгуу.

The problem of translating the meaning of Russian conditional verbs into Mongolian

(On the example of translating Sholokhov M.'s story “The Fate of Man”)

Erdenemaam Sosorbaram 

Advising Professor,
Russian Language Department, School of Social Science and Humanities,
Mongolian National University of Education,
Ulaanbaatar, Mongolia

Abstract: One of the many topics which cause considerable difficulties for Mongolian students studying Russian is the Conditional Verbs and their translation. Therefore, in this article we will discuss the formation, function, and features of the use of Russian Conditional Verbs, as well as how to translate them into Mongolian. As example of how to translate is taken from the famous story “The Fate of Man” by the famous Russian – Soviet writer and Nobel Laureate Sholokhov M., translated by the leading Mongolian scholar and renowned translator of the XX century, one of the founders of our country’s modern literature, State Laureate Rinchin Byamba.

The main result of this article: provide detailed information from master and doctoral level courses on Russian Conditional Verbs, discuss the different positions of scholars, report on the difficulties. Mongolian students face this topic, and present classic case studies translated into Mongolian.

Keywords: *conditional verb, perfect and imperfect condition, principle of correspondence and equivalence, national identity*

Ном зүй

Буслаев, Ф. И. О преподавании отечественного языка // Соч. Федора Буслаева. — Москва: бр. Салаевы, 1867. — [4], IV, 472 с.: 24.

Галсан С. (1975) Сопоставительная грамматика русского и монгольского языков. УБ., стр. 264.

Галсан, С. (1976). *Орчуулга сөхөхөд*. Орчуулах эрдэм.

Кудрявский. Д.Н. (1916). К истории русских деепричастий. Вып. 1, стр. 24.

Ломоносов, М. (1755). *Российская грамматика*. С-Пб.

Ломоносов.М. Страница автора: стихи, статьи. (n.d.). In *Русский биографический словарь*. <https://litera.ru/stixiya/articles/783.html>

Ломтев. Т. П. (1961). Сравнительно-историческая грамматика восточнославянских языков, М., стр.89.

Чернышев. В.И. (1914). Правильность и чистота русской речи: опыт русской стилистической грамматики / В. Чернышев. - 3-е изд., сокр. - СПб. Тип. М. Меркушева, стр.119.

Шолохов М. (1967) Хүний хувь заяа. Орчуулсан Б.Ринчин. УБ., Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо.

Өнөрбаян.Ц. (2004). *Орчин цагийн монгол хэлний үгзүй* . УБ.

Русская грамматика (Vol. Том I). (1980). М.